

ЗОХИОЛЧ Л.ВАНГАН БА “ЭРХИЙ МАЖИГ” (1965)
ТУУЖИЙН ГОЛ ДҮРИЙН УРЛАЛ

Г.Галбаяр

Түлхүүр үг: Л.Ванган, “Эрхий Мажиг”, дүр, тууж, урлал, уран дүрслэл

Оршил

XX зууны Монголын уран зохиолын нэрт төлөөлөгч, театр, киноны суут найруулагч, соён гэгээрүүлэгч бол Ламжавын Ванган (1920-1968) билээ. Л.Ванган олон арван жүжиг бичиж, орчуулж, тэр бүхнээ монголынхоо театрын тайзнаа найруулан тавьж, үзэгч олноо соён гэгээрүүлсэн гавьяатан. Нийгмийн алив нэг бусармаг зүйлийг гярхай ажиглаж, товч тодорхой уран сайхан дүрслэлээр бичсэн хошин шог өгүүллэг, туужууд нь ч үе үеийн уншигчдын ёс суртахуун, мэдлэг боловсролд төдийгүй монголын уран зохиолын хөгжилд чухал хувь нэмэр оруулсаар ирсэн билээ.

“1960-1970 оны үе бол монголын уран зохиолд туужийн төрөл зүйл их хурдацтай хөгжсөн үе юм. Ардын хувьсгалын жилүүдэд (1921-1980) гарсан бүх туужийн 90 орчим хувь нь энэ үед бичигдсэний 20 гаруй хувь нь жараад онд, 70 орчим хувь нь далаад онд гарчээ. Энэ бол өмнөх үеүдтэй харьцуулж авч үзсэн ч уран зохиолын бусад төрөл зүйлтэй харьцуулж үзсэн ч анхаарал татах үзүүлэлт юм” (Ред. Сампилдэндэв, 1997:226). Монголын зохиолчдын III их хуралд: “Манай үргэлжилсэн үгийн зохиолчид дотор тууж бичээгүй хүн бараг байхгүй. ... үргэлжилсэн үгийн том хэлбэр тууж бичих явдал өргөжиж, сэдвийн хүрээ нь нэмэгдэж амьдралын олон талд чухал асуудал тусгалаа олж байгаа нь манай утга зохиолын сүүлийн үеийн хөгжлийн нэгэн сайн тал мөн.” (МЗЭ, 1964:24-25) гэж онцлон өгүүлсэн байна. 1960-аад оноос тууж олноороо бичигдсэний зэрэгцээ төрөл зүйл нь илт баяжсан байна. Тухайлбал, энэ үед хошин шог туужууд бичигдэж эхэлсний нэг нь Л.Ванганы “Эрхий Мажиг” (1965) тууж юм. Уг туужийг хэвлэгдсэний дараа судлаач Ш.Цэнд-Аюуш “Монголын нэрт зохиолч Л.Ванган “Эрхий Мажиг” гэдэг сонин сайхан тууж бичжээ. Түүний онцлог нь үйл явдлын сонирхолтой зохиомж олж, санаагаа инээдэмтэй хошин байдлаар илэрхийлсэнд байгаа юм. ... Хошин шог тууж үйл явдлын өрнөл, зохиогчийн дэвшүүлэх санааг сонин инээдэмтэй өрнүүлж шийдвэрлэн, инээдмийн арга аясаар бичихийг шаарддаг. Энэ нь түүний гол онцлог юм. Энэхүү онцлогоос хамаарч инээдмийн туужид баатрууд нь инээдэм үүсгэх нөхцөл орчинд заавал байх, уран хошин сэтгэж, үг ярианы хувьд ончтой, мэргэн, шинж төрх, үзэл бодлын хувьд хурц, сэрэмтгий байх ёстой. Ийм байж л хошин шог тууж сая төрх төлөвөө олж авдаг” (Цэнд-Аюуш, 1981:41) гэж уг туужийн тухай бичжээ. Туульсын зохиолын том төрөл зүйл болох тууж бичих нь төвөгтэй ажил, тэр дундаа инээдмийн өнгө аястай, шүүмжлэлт сэтгэлгээ бүхий хошин шог тууж бичих нь амаргүй ажил байсан нь мэдээж хэрэг.

Уран зохиол бол нийгмийн тусгал, хүний амьдралын уран сайхны илэрхийлэл. Нийгэм болоод хувь хүний амьдрал тухайн иргэн хүнээс шууд хамаардаг тул зохиолчийн намтар түүх, үзэл баримтлал, урлан бүтээх арга барил нэн тэргүүнээ дүрийн урлалд чиглэгддэг байна. Өөрөөр хэлбэл, зохиолын уран сайхан, үнэт зүйл нь тухайн зохиолын дүрийн урлалаас шууд хамаардаг гэсэн үг. Уран зохиолын энэ ерөнхий шинжид тулгуурлан зохиолч Л.Ванганы “Эрхий Мажиг”

туужийн гол дүрийн урлал нь уг зохиолоо хошин шог аястай туужийн төрөлд хүргэхэд ямар үүрэг гүйцэтгэснийг, улмаар зохиолч Л.Ванганы уран сайхны эрэл хайгуул, хүрсэн үр дүнг нь амьдрал, үзэл баримтлалтай нь холбон тодруулахыг энэ удаад чухалчилж үзлээ. “Эрхий Мажиг” тууж нь ухаан санаа сэргэлэн, ажигч гярхай, төлөв төвшин хүмүүжилтэй ч төрөлхийн намхан тагжгар Мажиг сумын сургуулийн нэгдүгээр ангид сурч байхдаа өөрөөсөө өндөр ахлах ангийн хэд хэдэн хүүхдийг нэгэн удаагийн барилдааны үеэр төвөггүй давах үеэр сургуулийнх нь нэг хочич жаал “Эрхий” хэмээн хочилж, улмаар насаараа “Эрхий Мажиг” гэж нэрлэгдэх болсон Мажиг бага, дунд сургууль, улмаар их сургуулиа амжилттай сайн төгсөж, Хөдөө аж ахуйн яаманд мэргэжилтэн болж, ажилдаа хэрхэн туршлагажиж, амьдралаа хэрхэн тохижуулж байгааг хошин өнгө аястайгаар дүрсэлсэн зохиол. Энэ зохиол олон удаа хэвлэгдсэнээс бид энэ удаад 1971 онд Монголын Зохиолчдын Хорооноос эрхлэн хэвлүүлсэн Л.Ванганы “Хэн хэлсэн юм бэ?” (Ред. С.Дашдондог) түүвэр зохиолын 558-605 дугаар талд хэвлэгдсэн эхийг гол сурвалж болгон авсан болно.

I. Зохиолч Л.Ванган, Мажиг (“Эрхий Мажиг” туужийн дүр) нарын холбоо хамаарал

I.I. Зохиолч Л.Ванганы амьдрал, уран бүтээл

Зохиолч, найруулагч, төр нийгмийн нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч Ламжавын Ванган 1920 оны 11 сарын 20-нд Завхан аймгийн Түдэвтэй сумын нутагт Бор эрэг хэмээх газар төржээ. Аав Ламжав нь Улсын бага хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар томилогдсоноор тэднийх хотод шилжин ирж суурьшив. Л.Ванган 1930-1932 онд Улаанбаатар хотын үлгэр жишээ 3 дугаар бага сургууль, 1932-1935 онд дунд сургуульд суралцаад, 1935 оноос ЗХУ-д Рабфакт суралцахаар явжээ. Шүүх яамны сайдын албыг хашиж байсан аав нь 1937 онд улс төрийн хилс хэрэгт гүтгэгдэж шоронд орсон тул эсэргүүгийн хүүхэд хэмээн Л.Ванганг Рабфакаас хөөсөн ч хожим 1946-1951 онд ЗХУ-ийн Луначарскийн нэрэмжит Театр урлагийн дээд сургуульд найруулагчийн мэргэжлээр суралцаж төгссөн түүхтэй. Л.Ванганы аав Ламжав хилс хэргээр 10 жил шоронд сууж суллагдаад энгийн иргэн хүний амьдралаар амьдарч яваад 1962 онд цагаадсан бол ээж Намжийн нь 1936 онд нас барсан аж. Аав ээжийнхээ болоод өөрийнхөө товч намтрыг Л.Ванган 1964 оны 6 сарын 14-ний өдөр өөрийн гараар бичиж үлдээсэн нь Монгол улсын үндэсний төв архивд зохиолч Л.Ванганд холбогдох материал “БНМАУ-ын Урлагийн гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт Ламжав овогтой Ванганы хувийн хэрэг, холбогдох баримт, 13 ширхэг гэрэл зурагтай, бүгд 166 хуудас. 1968.12.6” гэсэн нэртэйгээр хадгалагдаж байна. Энд бичсэн намтрыг нь судлаач Ж.Ууганбаатар “ЛАМЖАВЫН ВАНГАН” бүтээлдээ оруулсныг шууд ишлэн авч үзье.

Эцгийн түүх

Миний эцэг Баатад овогтой Ламжав нь 1902 онд одоогийн Завхан аймаг, Цэцэн сумын нутагт ард Долгорын 1-р хүү болон төржээ. 16 нас хүртлээ эх эцгийн гар дээр өсөн торниж мал маллаж байхын завсар монгол бичиг заалган сурч 17 наснаасаа эхлэн хушууны тал ба Жинхэнэ бичээч, Сум, Хушуу дарга, Аймгийн орлогч дарга, Намын хорооны хэлтсийн дарга, Ерөнхий сайдын нарийн бичгийн дарга, Шүүх яамны сайд, Улсын бага хурлын тэргүүлэгч мэтийн ажлуудыг 1937 оны 9-р сар хүртэл үргэлжлэн хийж яваад “хувьсгалын эсэргүү” гэгч хэрэгт холбогдон баригдаж 1937-1946 он хүртэл хоригдон шийтгэгдэж, 1946-1952 он хүртэл улсын циркэд барималчин, дархан, 1952-1964 он хүртэл Улсын театрт хөгжмийн засварч ба төмөрчингийн ажил хийж байна.

1961 онд Улсын цагаатгах комиссын тогтоолоор хилс хэрэгт шийтгэгдсэн гэж цагаатгагдаж Намын батлах ба гавьяа шагналаа буцаан авч, мөнгөн тэтгэвэр өгөгдсөн болно. Одоо Улсын дуурь бүжгийн театрт хөгжмийн засварчаар ажилласаар байгаа ба нас 63 хүрчээ.

Эхийн түүх

Эх Намжий нь 1905 онд Завхан аймгийн Чандмань-Өлзийт сумын нутагт ард Зайсан гэгчийн 2-р охин болж төржээ. Багадаа эх эцгийн гар дээр өсөөд мал маллаж дараа нь манай эцэг Ламжавтай ханилан сууж 1926 онд намын гишүүнд элсэж орон нутагт эмэгтэйчүүдийн байгууллагад бага зэрэг ажил хийж, 1931-1933 оны үеэр Хотын гар үйлдвэрт оёдолчны ажил хийж байжээ. ... 1936 онд нас барсан болно.

Ванган миний түүх

Завхан аймгийн Түдэвтэй сумын нутаг “Бор эрэг” гэдэг газар 1920 онд Ламжавын анхдугаар хүү болон төржээ. 1931 оноос 1935 он хүртэл бага дунд сургуульд сурч, 1935-1938 он хүртэл Улаан-Үдэ хотод Монгол рабфакийн сургуульд сурч байтал “эсэргүүгийн хүү” гэж цэвэрлэгдэн хөөгдөж, 1938 оноос 1939 он хүртэл ажил хөдөлмөр, сургууль ч үгүй хэсэж өнгөрүүлсэн билээ.

1939 оны намар Төв хорооны зөвшөөрөлтэй Холбооны техникумд багшилж, “Дэлхийн байдал, Байгаль” заах багш ба курст хэлмэрч хийж, 1940 онд техникумд тоо физик зааж ахлах багш болон ажиллаж байтал, 1940 оны 5-р сарын орчмоор Намын төв хорооны шийдвэрээр Улсын театрын дэргэдэх Циркийн ангид дагалдан жүжигчин хийж, 1941 онд “Циркийн студи” хэмээх нэг жилийн курсийг төгсгөж, Улсын цирк гэж анх байгуулагдахад жүжигчнээр ажиллаж, 1944 оны үеэр найруулагч, 1946 оны үеэр уран сайхны удирдагч болон ажиллаж байгаад 1946 оны намар Москва хотын Луначарскийн нэрэмжит Театрын дээд сургуулийн найруулагчийн ангид орж суралцаад, 1951 оны намар төгсөж ирээд 1951 оноос 1956 он хүртэл найруулагч, уран сайхны удирдагчийн ажлыг хийж, 1956-1959 он хүртэл Соёлын яамны орлогч сайдын ажил хийж, 1959-1963 он хүртэл УХДТеатрын уран сайхны удирдагчийн ажлыг хийж, 1963 оны 5-р сараас эхлэн Кино үйлдвэрийн уран сайхны удирдагчийн ажлыг хийж явна.

Энэ завсар Хотын намын бүгд хурлын гишүүн, Үйлдвэрчний төв зөвлөлийн бүгд хурлын гишүүн, Улсын их хурлын депутат, Монголын зохиолчдын хорооны нарийн бичгийн дарга мэтийн сонгуулийн үүргүүдийг хүлээж явсан. Одоо Соёлын яамны намын хорооны товчооны гишүүн, Зохиолчдын хорооны нарийн бичгийн даргын сонгуультай байна. Хуулиар ял шийтгэгдэж яваагүй.

1944 онд Намын батлах гээгдүүлж донгодуулсан. 1961 онд Намын сахилга алдаж ууж согтуурсан явдалд донгодуулсан. 1963 онд “Түмний нэг” гэдэг кино зохиолын хоёрдугаар ангид үзэл суртлын алдаа гаргасан явдалд МАХН-ын Төв Хорооны улс төрийн товчооны тогтоолд тэмдэглэгдсэн болно.

Урлаг, утга зохиолын ажилд амжилт гаргасан гэж Засгийн газрын хүндэт үнэмлэхээр 2 удаа, Хөдөлмөрийн медаль, XXV жил медаль, 40 жил медаль, Алтан гадас одон, Төрийн шагнал, Урлагийн гавьяат зүтгэлтэн цолоор шагнагдаж явсан болно.

Гэр бүлийн талаар ...1952 онд Түмэнбаярын Пялзаатай суусан одоо 4 хүүхэдтэй. Хадам эх Түмэнбаярын хамт ам бүл 7 болно. Эцэг Лхамжав ам бүл тусдаа амьдарч байна. Төрсөн дүү Л.Нацаг Улсын циркэд жүжигчин, ам бүл тусдаа амьдарч байгаа. 1943 оны 4-р сарын 8-нд Намд элссэн болно.

Товч намтар бичсэн: Ламжав овогтой Ванган (Ууганбаяр, 2019:6-9)

гэж тэмдэглэн үлдээжээ. Энд Л.Ванганы хийж байсан ажил, албан тушаал, гавьяа шагнал бүгд бичигдсэн байна. Тэр бээр энэ намтраа бичсэн 1964 оноос хойш өөрөө намтартаа бичсэн Кино үйлдвэрийн уран сайхны удирдагчийн ажлыг хийж байгаад 1968 оны 3 сарын 1-ээс Улсын драмын театрт уран сайхны удирдагчийн албанд томилогдож ажиллаад 1968 оны 12 сарын 6-нд таалал төгсжээ.

Л.Ванган 1940-өөд оны сүүлчээс уран бүтээлээ эхэлж, монголын орчин үеийн уран зохиол, театр, киноны салбарт ажиллаж эхэлжээ. Түүний туурвисан бүтээлүүд нь:

А. Үргэлжилсэн үгийн зохиол: “Бэлдээ буусан нь” (1960), “Мөн ч хэцүү байж ээ” (1963), “Сарьсан багваахай олширвол муу” (1964), “Жож Сэрээнэн” (1964), “Ээж ээ” (1965), “Эрхий Мажиг” тууж (1965), “За-гийн гай” (1968), “Хилсдэхгүй” (1968), “Далайд дусал нэмэр” (1968), “Хар шилт” (1968),

Б. Жүжгийн зохиол, дуурийн цомнол: “Эмч нар” (1953), “Цагаан хүзүүт майга бор” (1954), “Худалдагчийн зүүд” (1955), “Тожоо жолооч” /А.Дашнямтай хамт/ (1954), “Урагшлах замд” (1956), “Хувиа бодогчид” (1959), “Арвай хээрийн талд” (1962), “Тамирын бэр” /О.Цэндтэй хамт/ (1954), “Жирийн хүмүүс” (1965), “Эзэд” (1966), “Зам нийлэх үү” /П.Хорлоотой хамт/ (1954), “Ач хүүгийн зүүд” (1972), “Хөхөө Намжил” /Ч.Чимидтэй хамт/ (1979),

В. Кино тууж, уран сайхны кино: “Бямбаагийн зээрд” (1966), “Хэн хэлсэн юм бэ?” /Ч.Чимидтэй хамт/ (1967), “Талын цуурай” /С.Дашдооровтой хамт/ (1968), “Салхины амт” (1955), “Сэрэлт” (1957), “Түмний нэг” (1963), “Хүний мөр” (1965), “Талын цуурай” (1966), “Өглөө” (1967), “Тэмцэл” (1969), “Дайны тухай өгүүллэг” /С.Дашдооровтой хамт/ (1970),

Г. Орчуулга: А.Барянов “Тэр талд” (1949), С.Михайлков “Бардам туулай” (1954), Г.Пфрейфер “Дэнлүүний баяр” (1960),

Д. Найруулсан жүжиг: Хэ Цжин Дан И “Буурал бүсгүй” (1952), Б.Лавренев “Америкаас ярьж байна” (1953), А.Н.Островский “Аянга” (1953), Ахтанов “Арслангийн хувь” (1954), Хуа Дин “Тэмцлээр бойжсон нь” (1955), Л.Ванган “Урагшлах замд” (1956), Ч.Чимид “Босгон дээр” (1959), Ч.Чимид “Эргээд харахад” (1960), Д.Намдаг “Шарай голын гурван хаан” (1961), Д.Намдаг “Шинэ зам” (1961), Д.Намдаг “Ээдрээ” /Э.Оюуны хамт/ (1968) юм.

II. Зохиолч Л.Ванганы амьдрал, үзэл санаа “Эрхий Мажиг” туужийн гол дүр Мажигтай нь холбогдох нь

Л.Ванганы намтар түүхээс харвал тэр зовлон их үзжээ. Аав нь хэлмэгдэж арван жил шоронд суухад ар гэр, дүү нараа өсгөн, сургуулиасаа эсэргүүгийн хүүхэд хэмээн хөөгдөж байжээ. Мөн бас зарим уран бүтээлээсээ болж буруудаж явсан түүхтэй аж. Амьдралдаа тохиосон хар бараан, ахуй нөхцөлөөс үүссэн муу муухайг дахин давтуулалгүй, хичээж зүтгэсний хувьд олноо “Л.Ванган багш”, “найруулагч Л.Ванган”, “зохиолч Л.Ванган” гэх зэргээр нэрлэгдэн түүхэнд үлдсэн суут хүмүүн болж чадсан нь түүний туурвисан “Эрхий Мажиг” туужийн Мажигийн дүр лүгээ адил харагдана. Учир нь зохиолч Л.Ванганы бага залуугийн зовлон зүдгүүрт амьдрал эзнийхээ эрдэм ухаан, хичээл зүтгэлээр хувьсан өөрчлөгдөж, “агуу суутан” болсон бол Мажиг бас л бага залуудаа цөөнгүй зовлон бэрхийг туулсны эцэст олны хайр хүндэтгэлийг хүлээж байгаа нь зохиолчийн намтар түүх, уг тууж хоёрт ямар нэг нарийн нандин холбоо байгааг харуулна. Л.Ванганы эхнэр Т.Пялзайн дурсамжид “Л.Ванган гэдэг том уран бүтээлч чинь ямар сонирхолтой намтар түүхтэй хүн бэ? Унаж босож, зөвдөж буруудаж” явсан тухайг нь, тэр дундаа нэг алдсан алдаагаа дахин давтаагүй ухаалаг нэгэн байсан тухай дурсан өгүүлсэн нь, “А.Д.Попов багшийн шавь Ламжав гуайн хүү, эгэл даруухан хөдөлмөрч, чийрэгхэн биетэй бор залуу” (Л.Ванган. Бүрэн зохиол-III. 2020:225) хэмээсэн зураглал “Эрхий Мажиг”-ийн Мажигийн дүрийг эрхгүй санагдуулна.

Ардын уран зохиолч Д.Пүрэвдорж түүнтэй анх хэрхэн уулзсан тухайгаа “Уран сайхны удирдагч Л.Ванган гэдэг хүний хаалгыг тогшиж анх ороход, намхан ширээний араас дөнгөж цухуйж байсан “мундаг эрийн” царайг анх харсан минь тэр” (Л.Ванган. Бүрэн зохиол-III, 2020:340) гэж дурсан өгүүлсэн байдаг нь зохиолч Л.Ванган “Эрхий Мажиг” туужийнхаа Мажиг шиг шавилхан биетэй нэгэн байсныг гэрчилнэ. Үеийнхэн нь түүнийг “хар пиджак өмсөж, берет малгай хазгайдуухан духдуулчхаад халхгар шар цүнх барьсан алхаа зөөлөн, нуруу намхан, авьяас билигт эгэл хүмүүн” хэмээн тодотгосон байгаа нь түүнийг Эрхий Мажиг шиг намхан нуруутай ч бэлчээр томтой, зангаргатай эр байсныг гэрчилнэ. “Эрхий Мажиг” туужийн Мажиг бол аливааг их боддог, тэр хэмжээгээрээ ямагт зөв зүйлийг олж сэддэг дүр,

гэтэл амьдрал дээр найруулагч Л.Ванганыг театрынхан “Боддог Ванган” гэж онцлон нэрлэдэг байжээ. Тэгвэл эрдэмтэн зохиолч Б.Ринчен “Энэ Л.Ванган гэдэг хүн эрхий хуруундаа эрдэм чихээд ирсэн хүн байна шүү дээ” (Л.Ванган. Бүрэн зохиолын-III, 2020:349), Төрийн шагналт, яруу найрагч Б.Явуухулан “Энэ муу жаахан Ванган хэр баргийн зуун зохиолчтой тэнцэнэ” (Л.Ванган. Бүрэн зохиол-III, 2020:354) гэж үнэлж байсан нь “Эрхий Мажиг” туужийн Мажигийг л хэлсэн мэт санагдана.

“Хүний мөр” (1963) киногоо “үндсэрхэг үзэл” тусгасан шалтгаанаар хаалгаж, Д.Цэдэнбал дарга тэргүүтний заавар захиалгаар дахин уг киногоо шинээр хийж, нэг ёсондоо алдаж онож явсан нь “Эрхий Мажиг” туужийн Мажиг хөдөө аймагт томилолтоор яваад яамныхаа хурлаар донгдуулж, дахин дараа жил нь тус аймагтаа очиж үр бүтээлтэй ажиллаж байгаа нь мөн л Л.Ванганы намтар түүх буюу Мажигтай бага ч гэсэн холбоотой мэт санагдана. Хорвоод санамсаргүй зүйл үгүй л гэдэг дээ! Хөдөөг соён гэгээрүүлэх, хөдөөгийн театруудыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн ажлууд нь хөдөө очиж ажиллаж, мал аж ахуйн салбарыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэхээр ажиллаж байгаа зоо техникч Мажигтай ч төстэй.

Гавьяат жүжигчин Г.Батсүх гуай “Л.Ванган багш маань хүний мөн чанарыг бүрэн агуулсан сайхан хүн. Хүнийг зүс царай, ахуй амьдралаар нь ялгаж үздэггүй, үнэн сэтгэлээсээ тэр хүнтэй нөхөрлөсөн бол нөхөрлөж, итгэсэн бол итгэдэг байлаа” (Л.Ванган. Бүрэн зохиол-III, 2020:313) хэмээсэн дурсамжид түүнийг хүний мөс чанар сайтай, хүнийг ялгаварлан гадуурхдаггүй гүдэс нэгэн байсныг өгүүлжээ. Түүний тухай ийм дурсамжуудыг Ардын жүжигчин С.Гэндэн, Ардын жүжигчин А.Очирбат, Гавьяат жүжигчин З.Жарантав тэргүүтэй олон хүний дурсамжаас тодруулан харж болно. Түүний “Эрхий Мажиг” туужийн Мажиг бас л олныхоо дунд оройлсон, овсгоо самбаа сайтай, хүний мөсөөр гүдэс сайхан дүр, нэг ёсондоо дээр өгүүлсэн манай алдартнуудын дурсамж дахь Л.Ванган Мажигийн дүрээс ургаастай.

Энэ бүх баримт бол “Эрхий Мажиг” туужийн Мажигийн дүр нь Л.Ванган өөрөө байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Энэ дүгнэлтийг зохиолч сэтгүүлч Б.Равдангийн “Ванган багш мөн “Эрхий Мажиг” туужийнхаа эх дүрийг Баян-Өлгий аймагт явж байгаад өөрөөсөө олсон гэдэг билээ. Казакстанаас ирсэн нэг албаны хүн Ванган багштай хамт хоол идэхдээ үл тоомсорлох дүр гаргаж байсан бол Төрийн соёрхлын тэмдгээ зүүчээд гоёлын хувцсаа өмсчхөөд байхад нь их хүндэтгэх дүр үзүүлж байснаас энэ зохиолын санаа анх төрсөн гэнэ.” (Л.Ванган. Бүрэн зохиол-III, 2020:395-396) гэсэн дурсамж баталж байна. Ийнхүү Л.Ванган өөрийнхөө дүрийг уран сайхнаар урласан учир Мажигийн нэрийг ч их бодож өгсөн бололтой. Мажиг гэсэн нэр нь итгэл найдварыг биелүүлэгч хэр нь аливаа зүйлийн тэнцвэрт байдлыг хадгалдаг ба үгийн эрчим долгион нь сэтгэлийн эрч хүч, тэмүүлэл бүхий утгыг илэрхийлдэг тухай орчин үеийн зарим нэр томьёо судлаач үзсэн нь бий. Ямар ч байсан Мажиг гэсэн нэрийн эрчим долгион, утга нь хөгжих урагшлах, дээшлэх дэвших утгатай нь энэ чиглэлийн судлаачдын судалгаанаас тодорхой харагдаж байна. Юм үзэж, нүд тайлсан, аливаа зүйлийн наана цааныг гүн ухаарсан хүний хувьд Л.Ванган өөрийнхөө дүрийг уран зохиолд дархлахдаа гүн гүнзгий бэлгэдэл утгатай чухал нэрийг сонгож авсан нь мэдээж хэрэг.

II. “Эрхий Мажиг” туужийн гол дүрийн урлал

II.1. “Эрхий Мажиг” туужид гол дүр Мажигийн дүрийг зохиолч урласан нь

“Алив уран сайхны бичвэр нь уран сайхны сэтгэлгээний нэгдмэл тогтолцоо бөгөөд түүнийг бүрдүүлж байгаа гол махбод нь дүр болно. Уран зохиолын дүр ямар нэгэн агуулга илэрхийлдэг ч нөгөө талдаа зохиолыг биежүүлэн бүрдүүлэгч материал, зохиолын бүхий л хэрэг явдлыг зохион байгуулагч хүчин зүйл болдог. Ийм учраас дүр урлаг, уран зохиолын хамгийн нийтлэг мөн чанар, ер бусын байдал, гоо сайхныг тайлах онолын гол зангилаа ухагдахуун болно”. (Галбаатар, 2012:138) Учир иймд зохиолын үнэ цэн, учир утгыг тайлбарлахад тухайн зохиолын дүрийн өсөлт хөгжилт, үзэл санааны өөрчлөлт хувирлыг нэн тэргүүнээ авч үзэх хэрэгтэй. Уран зохиолд дүрийг олон аргаар урлаж болохын нэг нь зохиолч хөндлөнгөөс хүүрнэн өгүүлэх

маягаар дүрээ хөгжил хөдөлгөөн дунд нь урлах арга юм. Энэ аргыг зохиолч Л.Ванган гарамгай сайн эзэмшсэн нэгэн байсныг түүний “Эрхий Мажиг” туужийн Мажигийн дүрээс тодорхой харж болохоор байна.

Эрхий хуруу шиг жижиг биетэй ч эрхий хурууны илэрхийлэл шиг сайн ажилладаг Хөдөө аж ахуйн яамны мэргэжилтэн Мажигийн тухай зохиолч, “Мажиг тохилог албан тасалгаанд бичиг цаас эргүүлж, утас шөрмөсөөр ярьж байцааж, зааварлаж, шалгаж, тушааж, их л подгор суудаг. Гэвч орж ирсэн хүмүүс тоодоггүй нь харамсалтай. Тэр ч битгий хэл, гаднын тэр улс голдуу өөрөөс нь,

- Мажиг гуай хаа байдаг юм бэ? гэж асуудаг удаа олон бий.

- Би байна, гэхээр зарим хүн зовох маягтай байвч олонх нь “Чи юу” гэсэн байдалтай их хардагт нь Мажиг бас л дасаж гүйцжээ.

Заримдаа орон нутгаас ажлаар орж ирсэн хашир арслангууд,

- Ах нь практик дээр үзсэн юм, энээ тэрээ гээд гэнэдүүлчих гээд байхыг нь яанаа? Мажиг дадлагатай хашрууд давуулчаад дарга сайд нарынхаа өмнө гөлөлзөж ч явж,

- Давдаггүй даваа юм, яасан хэцүү хүүхэд вэ, юмыг чинь аргы нь олж болдогсон гэж хэлүүлээд эрдэж ч явж.” (558-559 дүгээр тал) хэмээн хүүрнэн зурсан зураглалаараа Мажигийг ажил дээрээ өсөж яваа, ирээдүйтэй нэгэн гэдгийг хошин шог аястайгаар сонирхолтой өгүүлсэн нь Мажигийн дүрийн урлалд төдийгүй монголын орчин үеийн уран зохиол дахь дүрийн урлалд сонирхолтой шинэ шийдэл болжээ. Учир нь тухайн агшинд сөрөг үнэлэмж илэрхийлсэн хоч, ажил үйлийн өсөлт дэх эсрэг үнэлэмжийг уншигчийн уншвараар дамжуулан үзэл бодолд нь хүргэхдээ дүрийнхээ эерэг өсөлтөд сөрөг үнэлэмжийг нь хошин шог аясаар далдлан уусган идээшүүлж, тэрхүү идээшсэн дүрслэл дунд дүрээ сонирхолтойгоор урлан товойлгож, урлагдан товойсон дүрээрээ уншигчдын анхаарлыг татаж, татсан уншигчдын анхаарал дээрээ эргүүлээд дүрийн хөгжлийн цаашдын замналын хөрсийг бэлдсэн байна. Зохиолын дээрх ишлэлийн хэсгийг уншсан хэн ч байсан зохиолыг цааш нь үргэлжлүүлэн унших биз. Өөрөөр хэлбэл, зохиолч Л.Ванган зохиолынхоо дүрийн урлалд хөндлөнгөөс хүүрнэн оролцохдоо илбэ шидийн мэт өвөрмөц увдистай уран чимхлүүр дүрслэлийг деталь хэсэг бүрд урнаар шигтгэн өгдөг онцлогтой нэгэн байжээ. Энэ нь түүнийг их уншсан, ажигч гярхай нэгэн байсныг гэрчлэхийн зэрэгцээ XX зууны монголын уран зохиол дахь дүрийн урлалд чухал түлхэц болсон билээ.

Мажиг нэгэн аймгийн хөдөө аж ахуйн хэлтсийн ажлыг шалгаж зааварлахаар сарын томилолт аваад явахдаа өвлийн идэр хүйтэнд өмсөх хувцас, бичиг цаас тэргүүтнээ хүн хүнээс гуйж аваад өмссөн хувцсандаа түүртэж, ачаа барааныхаа хажуугаас өндийж чадахгүй “амьтан” тээврийн товчоо орж, “шуудангийн машин өөд юмаа цувуулан гаргаж, араас нь өөрөө гарах гэж мунгинасаар байхад нь ашгүй нэг, өөр хүн үдэж явсан хижээл авгай,

- Иш чааваас энэ нэг амьтныг! гэж дуу алдан хөлнөөс нь дэмжээд арайхийж машин дээр гаргатал, аль тохитой байры нь хэзээний улс эзлээд тавлаад суучихсан байжээ. ... (560 дугаар тал) мэтээр мунгинаж явсаар зорьсон аймагтаа очиж, хөдөө аж ахуйн хэлтсийн даргын өрөөний үүдэнд очоод,

“- Орох уу? гээд түтгэлзэнгүй гэлдэрсээр хэлтсийн даргыг ажиглав. Урдах ширээндээ томдсон янхир хүрэн хар хүн, тавь гаруй настай болуу гэмээр буурал орсон мухар тунжин толгойгоо өргөж Мажигийг ширүүн хараад гар барин мэндлэхийн зөв өгсөнгүй” (562 дугаар тал) өөр зүйл яриад, дараа нь хотоос өөрийнх нь ажлыг шалгахаар яваа яамны мэргэжилтэн болохыг мэдэж, амьдрал, практик ярьсаар амархан аргалж, аргадаа оруулж байгаа хэсэгт Мажигийг хэрхэн хөглөж, алдаж онож байгааг инээдэмтэй урнаар хүүрнэн урласан байна. Мажиг хөдөө явахдаа өмсөх дулаан хувцас байхгүй хүн хүнээс гуйж, эвлүүлж дэвлүүлээд болгож байгаагаар түүний амьдрал боломж муутайг, хүмүүс тал бүрээс нь дэмжиж өөрт байгаа зүйлсээ харамгүй өгч тусалж байгаа нь түүнийг хамт олонтой, ааш зан сайтай, нөхөрсөг нэгэн гэдгийг урнаар далдлан дүрсэлсэн байгаа нь шинэлэг төдийгүй өвөрмөц уран дүрслэл болжээ.

Дээр жишээ болгон ишилсэн хоёр хэсгээс монголын уран сайхны киноны зарим дүр, деталь хэсгүүд өөрийн эрхгүй урган харагдана. Үүнийг бичигч миний бие дээрх хоёр хэсгийн ишлэлийг нэг ангийн 24 оюутнаар уншуулан,

- Монголын уран сайхны киноны ямар нэг хэсэг санаанд чинь бууж байна уу? хэмээн асуухад бүгд,

- Мэдэхгүй, санаанд буусан зүйл үгүй гэж хариулав. Харин 40, 50 орчим насны хэд хэдэн (12 хүнээс) хүнээс дээрх асуултыг асуувал бараг бүгд,

- Эхний ишлэл дэх “Ах нь практик дээр үзсэн юм, энээ тэрээ гээд гэндүүлчих гээд байхыг нь яанаа? Мажиг дадлагатай хашрууд давуулчаад дарга сайд нарынхаа өмнө гөлөлзөж ч явж,

- Давдаггүй даваа юм, яасан хэцүү хүүхэд вэ, юмыг чинь аргыг нь олж болдогсон гэж хэлүүлээд эрдэж ч явж” гэсэн хэсгээс “Ээ дээ энэ хүүхнүүд үү” (1963 онд гарсан. Ч.Лодойдамбын зохиол, Р.Доржпаламын найруулсан кино.) киноны нэгдлийн дарга Жамц гуайн дүр, тэр дундаа Жамц дарга нэг удаа хот орж, нэгдэлдээ дизель цахилгаан станц цохуулах гээд нэгэн санхүүгийн хүүхнийг учирлаад чадахгүй байдаг дүр зураг, нөгөө ишлэлээс нь,

- “Анхны алхам” (1969 онд гарсан. Ч.Гомбын зохиол, Г.Жигжидсүрэнгийн найруулсан кино.) киноны өвгөчүүд, тэр дундаа Нямын Цэгмэд гуайн бүтээсэн Балдан өвгөний дүр ургаж байна гэж бараг бүгд (дунд насны болоод нас хэвийсэн 12 хүнээс асуусны 9 нь) ижил хариулж байна. Надад ч ийм дүр зураг шууд харагдсан. Энэ бол зохиолч Л.Ванган уран сайхны кино болоод бусад зохиол, ерөөс амьдралыг онцгой гярхай нарийнаар ажиглаж, тэндээс уран сайхны боловсруулалт хийн зохиолынхоо дүрийг сайн урладаг байсныг, нөгөө талаар бусад зохиолч, найруулагч нөхөд түүний зохиол бүтээлээс бүтээлчээр суралцаж байсныг харуулж байна. Энэ бүхэн Л.Ванган зохиолынхоо дүрийн урлалыг төгс хийдэг уран бүтээлч болохыг харуулж байгаа хэрэг.

Зохиолч Л.Ванган дүрээ хөндлөнгөөс нь урлахдаа уран сайхны дүрслэлийн аргуудыг оновчтой ашиглаж, өвөрмөц дүрслэл бүтээж чадсан тул түүний зохиолын дүрүүд дахин давтагдах боломжгүй өвөрмөц уран сайхны илэрхийлэл болсон онцлогтой. Тухайлбал,

- Мажиг албан газартаа орон сууц олгож өгөөч гэсэн өргөдөл гаргахад, эхнэр авсныхаа дараа энэ асуудлаа дахин яриарай гэсэн хариуг сонсох үеийн түүнийг зохиолч “Мажиг өөрөө уриад оруулах оронгүй, уяруулаад татах авьяасгүй, алд бие нь сүрээр бага, авхаалж залиар уг нь дуль, малгай тавибал манайх, маргааш болбол хүний гэж яваа амьтан” (567 дугаар тал) гэж дүрсэлсэн,

- Мажиг нэгэн намар суух айл хайж, яахаа мэдэхгүй явтал цаг хатуурч, цас унах болсныг зохиолд “Мажиг бас хатуу шийдэж чадахгүй эргэлзсээр явтал уул цастаж, ус мөстөж, улс амьтан чигээ олж гүйцжээ.” (568 дугаар тал) гэж дүрсэлсэн,

- Мажиг хөдөө аймагт томилолтоор очиж буусан буудлын өрөөгөө “Түр ч гэсэн төлөөлөгчийн гэр, өртөгтэй ч гэсэн өөрийн ор” (569 дугаар тал) хэмээн тухалж байгаа,

- Мажиг нэгэн удаа Сэлбийн захын нэг гуанзанд орж захиалсан хоолыг зохиолд “амнаас мултармаар амттай, хоолой давахдаа төвөгтэй, ходоодонд ороод зовиуртай” (579 дүгээр тал) хоол ирсэн ч “янчаанаа өгсөн нэг хүч, ядарч өлссөн хоёр хүч нийлээд цөмийг нь цохичихсон чинь хамт ширээн дээр сууж байгаа арьсан царайтай, сарьсан хүзүүтэй хар хүн” (579 дүгээр тал) хэмээн урнаар тодотгосон дүрслэл,

- Мажигийн найз Нямбуугийн ах Содном мань хоёрт айлдвар айлдахдаа “хүн гэдэг чинь ...Халтирахгүй бол хашир суухгүй, зовохгүй бол зориг орохгүй гээч! Залуу явахад залхуу чөдөрлөнө. Тогтоод ирэхийн үед толгой дутна. За тэгээд монгол хүн гэдэг үү ... Чихээрээ биш чимхэж мэддэг, даарч үзэж байж дах нөмөрдөг, гэрлэсэн хойноо гэдсээ боддог, гэмтсэн хойноо эргэж хардаг мөн ч уужуухан дотортой улс юм шүү дээ” (582 дугаар тал) гэсэн сургаалын дүрслэл,

- Зохиолын төгсгөлд Мажиг хөдөө орон нутагт ажиллаж байгааг зохиолч “Сүүл сүүлдээ сүрхий ч мэргэжилтэн гэж нэрлэгдэж, унасан мориндоо эзэн, улаан “Ява”-даа механикч болж чоно дайралдвал намнадаг, хөгшидтэй бол ярилцдаг, залуусыг бол залруулчдаг, халуун хүйтэн ямраас ч хаширч үзэхээ больсон, савхин дээл нь цайж гүйцсэн, сахал гэдэг нь сойз болсон, хүүхэд айлгамаар эр болчихсон гялалзуулж явсан” (597 дугаар тал) хэмээн өгүүлсэн хэсгүүдийн дүрслэлүүд Мажигийн дүрийн урлалд чухал тодотгол болжээ. “Эрхий Мажиг” туужийн нэгэн тод шинж нь зохиогчийн цэцэн мэргэн оновчтой үг хэллэг юм. Тэр нь уг дүртэйгээ сайн нийцэж холбогдсоноос хошин туужийн үнэ цэнг нэмж байна” (Цэнд-Аюуш, 1981:150).

II. II. “Эрхий Мажиг” туужид гол дүр Мажигийн дүрийг Мажиг өөрөө товойлгосон нь

“Дүр гэдэг бол ургуулан бодох бодлын хүчээр бүтээсэн гоо зүйн учир холбогдол бүхий тодорхойн зэрэгцээгээр нэгтгэн төлөөлсөн, хүний аж амьдралын дүр зураг юм” (Тимофеев, 1972:53). Зохиолын дүр нь хувь бодгалийн шинжтэйгээс гадна бодит амьдрал дээрх хүмүүсийн нийтлэг хэв шинжийг хадгалдаг тул тухайн дүрийн урлалд өөрийнх нь үг хэл, үйлдэл, дотоод бодол санаа чухал үүрэгтэй. Тиймээс урлаг, уран зохиолын онолд дүрийн хамгийн сайн урлал нь өөрийг нь өөрөөр нь товойлгон урлуулах арга болохыг онцлон өгүүлсэн байдаг. Зохиолч Л.Ванган жүжгийн зохиолч, найруулагчийн хувиар зохиолынхоо дүрүүдийг өөрийнх нь үг хэл, үйлдлээр товойлгон урлах арга барилыг гарамгай эзэмшсэн нэгэн байсныг “Эрхий Мажиг” туужийн Мажигийн үг хэл, үйлдлийн өсөлт хөгжилтөөс тодорхой харж болно. Тухайлбал,

- Сумын сургуулийн нэгдүгээр ангид байхад нь сургуулийнхаа нэгэн хочич хүүхдийн өгсөн “Эрхий” гэх хочинд яваандаа дассан Мажиг сүүлдээ бүр “Ер нь тэгээд таван хурууны эрхий гэдэг чинь муу ч хуруу биш. Тэр ч байтугай нилээн олон хэлний улс сайн юмыг илэрхийлэхдээ эрхий хуруугаа гозойлгох ч байдаг” (558 дугаар тал) хэмээн өөрийнхөө хочийг сайнаар тайлбарлаж байгаа нь түүний дүрийг зохиолд эрхий хуруу шиг ямагт сайн сайхан үйлийг хийдэг, амьдралын замнал дундаа өсөж өндийж яваа нэгэн болохыг товойлгон харуулж байна. Угтаа бол “биеэр бага ч бэлчээр томтой” нэгэн болохыг өөрийнх нь үгээр зохиолч урнаар өгүүлжээ. Зохиолч Л.Ванганыг яг энэ Мажиг шиг бие жижиг ч бэлчээр томтой, авьяас, эрдмээрээ халгиж цалгисан тэнгэрлэг нэгэн байсан гэж дурсах хүн захаас аван бий.

- Анхны томилолтоор очсон аймгийнхаа Хөдөө аж ахуйн хэлтсийн дарга Дампилравдан өвгөнд мэдлуулж, буцаж ирээд яамныхаа зөвлөлийн хурлаар “Нөхөр Мажиг тэр аймагт очоод тодорхой хийсэн ажилгүй, авсан ямар ч арга хэмжээгүй явжээ. Мажигийн энэ илтгэлд авах юм огт алга” (565 дугаар тал) гэж дүгнэгдээд явсан зам, хоногийн зардлаа төлөхөөр болсноо өөрөө “За ингээд муу эрхий Мажиг чигчий болох нь байжээ” (566 дугаар тал) хэмээн өөрийгөө тодотгож байгаагаар “эр эндэж эрэг нурдаг”-ийн үлгэрээр болсон ч “Мажиг ямар ажил амьдралдаа алдаа сэв гаргахгүй тавилантай төрсөн биш, эрхий хуруу нугарах ч бий, хугарах ч бий” (566 дугаар тал) гэж өөртөө дүн шинжилгээ хийж байгаа нь түүний дүрийг алдаж онодог хорвоогийн жамаар нэг удаа алдсан ч, алдсан алдаагаа ахиж давтахгүй ухаалаг нэгэн болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл, Мажиг бол алдаанаасаа суралцаж ахин дэвшсэн өвөрмөц дүр.

- Өмнөх жилийн шалгалтаар ирсэн аймагтаа дараа жил нь дахин ирж, урьд нь хууртагдсан хашир өвгөнтэй уулзаж ярилцах үеэрээ Дампил даргын яриаг сонсож суухдаа “хашрын энэ “уянгын халил” ч худлаа шүү дээ. Одоо муу дүүгээ мяндсан ногтоор хөтөлж төөрүүлж байгаад буцаах гэж байгаа юм. Ер нь хашрыг бага сонсож, өөрөө идэвхтэйхэн шалгах, шийдэх шугам баримтлах нь зөв” (569 дүгээр тал) гэж шийдэж байгаа нь дүрийн хөгжил, үзэл бодлын өөрчлөлт, ажлын дадлага туршлага суусныг харуулна. Энэ нь зохиолч Л.Ванган зохиолынхоо дүрийг өөрийг нь өөрөөр нь урлуулах “түлхүүр”-ийг гарамгай эзэмшсэн нэгэн байсныг илтгэж байна.

- Мажигийг хоёр дахь удаагаа хөдөө томилолтоор ажилласан тайлангаа хэлэлцүүлэхийг сайдын зөвлөлөөс утсаар хэлсэн эмэгтэйн тухай өрөөнийхөө Жамбад “-Дөч гарсан настай, дөрөв таван хүүхэдтэй, миний дайтай хоёрыг залгасан юм шиг нуруутай, саруулхан авгай, сайдын өрөөнд нэг дэх өдрийн 10 цагт гэж надтай болзож байна” (578 дугаар тал) хэмээн хошигнож байгаа нь түүнийг бэлэн цэцэн үгтэй, ам хэлээр хэний ч дор орохгүй яггүй нэгэн болохыг хэл ярианаас нь тодорхой харж болохоор байна. Зохиолч Л.Ванган ч уран цэцэн үгтэй, давхар санаатай яггүй эр явсныг түүний тухай дурссан алдартнуудын дурсамжууд батална. Түүгээр ч барахгүй Л.Ванган хэлсэн ярьсан зүйл, найруулсан найруулга зэрэгтээ дандаа давхар санаануудыг нэмж, түүнийгээ шаардлагатай үед хасаж тануулан үндсэн санаагаа авч үлдэж чаддаг аргатай байсныг өдгөө “Ванганизм” хэмээн нэрлэх болжээ.

- Мажиг хөдөө хэдэн жил ажиллаад хот орж семинарт суухаар ирээд зочид буудлын хүрэлцээгүйгээс болж Дампилравдан даргын сууж, охин Лхамдолгортой нь танилцаж, улмаар түүнд сэтгэлтэй болно. Нэгэн өдөр хөдөөгөөс ирээд айлаар хоног төөрүүлж байгаа Мажиг мэтийн нөхдийг буудалд оруулах болсныг сонсоод сэтгэлтэй хүүхэнтэйгээ уулзах шалтаг үгүй болох нь гэж ухаараад, тэр дороо “Тэднийхээр хааяа орж байх ганц шалтаг бол чемоданаа тэнд байлгах хэрэг. Өнөөдөртөө зочид буудалд очиж байраа олж авах нь зөв” (603 дугаар тал) хэмээн уран арга сүвэгчлэн сэтгэж байгаа нь түүнийг сэргэлэн авхаалжтай, ямар ч асуудлаас “хуурай” гарч чадах овсгоотой нэгэн гэдгийг эгзэгтэй үеийн шийдвэрээр нь дөвийлгөн дүрсэлжээ. Л.Ванган зохиолч аливаа асуудлыг маш хурдан шийддэг, шийдсэн зүйлүүд нь ямагт зөв байдаг байсныг үе тэнгийнхэн нь болоод шавь нар нь дурсан өгүүлсэн байдаг.

“Эрхий Мажиг” туужид харилцан яриаг түлхүү ашиглаж, тэрхүү харилцан яриагаараа дүрүүдээ тодруулсан онцлогтой. Энэ нь зохиолч Л.Ванган тайз дэлгэцийн салбарт олон жил ажиллаж, цөөнгүй жүжгүүд бичсэн учир дүрээ урлан бүтээх гол арга нь харилцан яриа болж төлөвшсөнийг харуулж байна. Тухайлбал, Мажиг хоёр жил дараалан нэг аймагт томилолтоор очиж, тус аймгийн Хөдөө аж ахуйн хэлтсийн дарга Дампилравдан хэмээх үхэхээс бусдыг үзэн хэрсүүжсэн өвгөнтэй уулзаж, ярилцах нь тун сонирхолтой. Учир нь эхний жил Дампил даргын өөртөө итгэлтэй хэр нь улам улмаар лавширсан ярианы хүч, эрчим долгион, тэр хэрээрээ Мажигийг зальдаж байгаа (560-565 дугаар тал) бол хоёр дахь томилолтын үеэр Мажигийн “хал үзэж, хашир суусан” хийгээд их сургуульд үзсэн онолоо ажлын туршлагаар баталгаажуулсан хүний хувьд өөртөө итгэлтэй байж, өвгөн даргыг гарах гарцгүй болгох яриа (569-577 дугаар тал), Мажигийн багын найзын ах Содном гуайн халамцуу үеийн яриа (580-582 дугаар тал), Лхамдолгорын Мажигтай танилцаж байгаа үеийн ичингүйрхэл (600-602 дугаар тал), хайр сэтгэлтэй болсон залуусын шийдвэртэй яриа (603-604 дүгээр тал) зэрэг нь тухайн үеийн нөхцөл байдал, сэтгэлийн хөдөлгөөнийг ярианы найруулгаар нь тодруулан дүрсэлсэн нь уг туужийн нэг чухал ололт болжээ. Ийнхүү “Туужид баялаг олон талтай, өргөн дэлгэр сэдвийг тусган дүрслэхдээ урлах эрдмийн хувьд өсөж, зохиолын зохиомж, үйл явдлын уялдаа холбоог өгүүлэн тоочих байдлаас үндсэн асуудалд төвлөрүүлж, тэгснээрээ нийгмийн амьдралыг уран сайхны дүрээр түүхэн тодорхой байдлаар нь дүрийн давтагдашгүй шинжийг сэтгэхүйн талаас нь нээн үзүүлэхэд их ахиц олов. Мөн зохиолчдын бүтээлийн уран санаа зохиомж, дүрслэл, хэл найруулгад мэдэгдэхүйц чанарын амжилт гарлаа. Тууж бичлэгийн хүрээнд эрэл, туршилт хийх эрмэлзэл идэвхжиж туужийн дотоод төрөл хэлбэр тодорхой хэмжээгээр ялгарч, хөгжлийн төлөвөө олсон байна. Энэ бүхэн нь 1960-1970-аад оны тууж бичлэгийн уран чадварын гол ололт мөн” (Ред. Сампилдэндэв, 1997:226).

II. III. “Эрхий Мажиг” туужид гол дүр Мажигийн дүрийг бусад дүрүүд тодруулсан нь

“Уран дүр гэдэг маань эцсийн эцэст “А бол Б шиг юм” гэсэн томьёолол бөгөөд амьдрал түүний үзэгдэл юмсын шинж чанарыг А гэж үзвэл Б гэсэн түүний төлөөлөл, харьцуулал, тодорхойлол, бэлгэдэл мэтийн үндсэн аргуудаар илэрхийлэгдсэн цогц гэж ойлговол зохино”

(Байгальсайхан, 1998:5). Уран сайхны дүр гэж амьдралын мөн чанарыг уран сайхны сэтгэлгээний үүднээс тодорхойн зэрэгцээ нэгтгэн дүгнэсэн дүр зураг бөгөөд тэр дүр зураг нь эргээд уран сайхныхаа үүднээс нөхөн сэргээгдэж уншигчдад гоо зүйн ач холбогдол өгч байдаг уран бүтээлийн түгээмэл ай учир тэрхүү дүрийг олон аргаар урлаж болдог бололцоо нөөц ихтэй зүйл. Дүрийг зохиолч хөндлөнгөөс хүүрнэн өгүүлэх хэлбэрээр урлахаас гадна дүрийг өөрийг нь өөрөөр нь товойлгон дүрслэх нь хамгийн түгээмэл үр дүнтэй арга. Тэгвэл тухайн зохиол дахь дүрүүдийн үг хэл, үйлдлийн харилцан үйлдлээр бие биеийнх нь онцлогийг тодруулах боломж буй. Энэ аргыг ч зохиолч Л.Ванган муугүй эзэмшсэн нэгэн байжээ. “Эрхий Мажиг” тууж дахь Мажиг болоод бусад дүрийн үйлдлээс Мажигийн дүрийн урлалын онцлогийг тодруулан харж болно. Тухайлбал,

- Мажиг урьд жил нь хууртагдсан Дампилравдан гуайн ажлыг дараа жил нь дахин шалгахаар ирэх болоход Дампил дарга “Одоо Мажиг ч Мажиг хүү биш дээ. Ингэх дээр шал өөрөөр жаалдаг хэргээ” (568 дугаар тал) гэж шийдэж байгаа нь Мажигийг хэнд ч дахин хууртагддаггүй, нэг алдсан алдаагаа дахин давтдаггүй хашир нэгэн болохыг үхэхээс бусдыг үзсэн хашир өвгөн Дампил даргын уран нүүдлээр дамжуулан тодруулсан нь дүрийн урлалд сонирхолтой шийдэл болжээ. Мөн энэ хэсэгт Мажиг Дампил хоёр өнгөрсөн жилийн шалгалтын тухай эргэн дурсаж ярилцах үеэр Мажиг,

“Та над үнэн сэтгэлээсээ хандаад туслаад өгч болох байсан шүү дээ гэв. ...Дампил,

-Тэгсэн бол, чи энэ жил бас л тэр хэвээрээ ирэх байсан шүү дээ гэхэд Мажиг нээрээ ч тийм юмуу даа гэж бодоод инээмсэглэлтэл, үүнийг ажсан Дампил гуай,

-Тийм тийм. Чи бол сургуульд онол заалгуулж, чээжилж шалгуулж, шалгуулах ч гэж дээ чээжилснийгээ пулемёт шиг шүршиж байж төгсчөөд, дараа нь бас л төвд сууж хөхүүл хүүхэд шиг эргэлдсэн бүхнээ асууж лавлаад, нэгний нь үгийг нөгөөхөд нь дамжуулж голцуу хэдэн өрөөний хооронд шогшиж яваа болохоос хөдөө газар толгой даагаад, өөрөө бодож шийдэж, зөвдөж, буруудаж амьдрал практик дээр туршсан юм огт байхгүй яваа хүн шүү дээ. Тэгэхэд чам шиг бэлээхэн онолтой хүнд, олон түмэндээ харуулах биеэн даасан бүтээл бас л хэрэгтэй байна даа?” (576 дугаар тал) гэж хэлж байгаагаар Мажигийн бодит нүүр царай, үйл хэргийг далд санаа агуулсан ч гэсэн хашир өвгөний ажиглалтаар зохиолч сонирхолтой хошин шог аясаар шүүмжлэн өгүүлсэн нь “хатуу үнэн үг явдалд тустай”-н үлгэрээр Мажигийн дүрийн ирээдүйн өсөлт хөгжилтийн үүдийг нээжээ. Энэ бол зохиолчийн хийсэн уран зохиомж, түүнээ чадварлаг илэрхийлсний үр дүн аж.

- Зохиолд Мажиг нэг хэсэг ганган Сумьяагийнхтай нэг байранд хамт амьдарч байгаад хөдөө орон нутагт ажиллахаар шийд гарах үед Сумьяа түүнийг хөдөө орон нутагт яаж амьдарна даа хэмээн өмнөөс нь зовонгуй өгүүлэхэд Сумьяагийн ээж “Энэ хүү яах ч үгүй, шавхийтэл ажиллаад тов хийтэл амьдарна” (596 дугаар тал) гэж хэлж байгаа нь Мажигийг хөдөө хөхөрч гадаа гандаж сурсан, хаана ч амьдрах чадвартай, юмны учир начрыг төвөггүй олж сурсан, нэг ёсны биеэ даасан бие хүн болсныг нь илэрхийлж байна.

- Мажиг хөдөө ажиллах шийдвэрийн дагуу “сурмаг гэгч нь юмаа эмхлээд танилуудтайгаа ярьж зөвөлчөөд” (596 дугаар тал) хөдөө явах замдаа хуучин танил Дампилравдан даргынхаараа дайрч уулзах үед Дампил дарга ихэд хүндэтгэн хүлээж аваад “Бид хоёрын өвлийн илэн далангүй яриа биеллээ олж байгаа нь, Мажиг хүү минь чиний л ач гэж” (596 дугаар тал) баярлан өгүүлж байгаа нь Мажигийг хүнд тусархуу, хүний бэрхшээл зовлонг зөв ойлгож, зөв зүйтэйгээр нь шийдүүлж чаддаг, угтаа бол яам тамгын газраа нөлөөтэй нэгэн болохыг товойлгон дүрсэлжээ.

- Мажиг семинарт суухаар хотод ирээд Дампилравдан даргын дүр саатаж охин Лхамдолгорттой нь хичээл номынх нь тухай ярилцаж байгааг эхнэр Нанжид нь хараад нөхөртөө хоёр залуугийн тухай ярихад Дампил дарга “Цаадах чинь харагдах бараанаасаа илүү мэдэцтэй эр дээ. Эрхий Мажиг гэж алдаршсаны нь чи бод” (602 дугаар тал) гээд Дампил эрхийгээ гозойлгож харуулахад, эхнэр нь “Шалгалтандаа бэлтгэж байгаа охинд минь саад л

битгий хийгээсэй” (602 дугаар тал) хэмээн эх хүний зөнгөөр залуусын дунд “учир ургаад” эхэлснийг хэлэхэд Дампил дарга эцэг хүний холыг харсан ухаанаар аанай л хуучин хэвээр бүр ч тааламжтайгаар “Тус л болно уу гэхээс ус ч гэж ярихгүй хүү шүү” (602 дугаар тал) гэж хэлэлцэж байгаа нь Мажигийг ноён нуруутай, хал үзэж, хашир суусан эр хүн болсныг, улмаар хүний сайн хань, хүүхдийн сайн аав болох нэгэн гэдгийг ирээдүйн хадам аав, ээжийнх нь яриагаар дамжуулан сонирхолтойгоор тодруулжээ.

Дүгнэлт

Монголын орчин үеийн уран зохиолын хөгжлийн явцад туужийн төрөл зүйл төлөвшиж, төрөл зүйлийн баяжилт болсны нэг илрэл нь Л.Ванганы “Эрхий Мажиг” хэмээх хошин тууж юм. Уг туужид гол дүрээ ажил хөдөлмөрийн явц дундаа дадлага туршлага, ухаарлын эрхээр хэрхэн өсөж, хөгжиж байгааг тухайн дүрийнхээ хичээл зүтгэл, бодол ухаарал, өөр бусад дүрүүдийн тус дэмүүдийн харилцан хамаарал дунд нь яруу сайхан хэл найруулга, өвөрмөц уран дүрслэлээр урласан нь зохиолчийн урлах эрдмийн өсөлтийг тодорхой харуулж байна.

“Эрхий Мажиг” туужид ярианы хэлний найруулгаар харилцан ярианы хэсгүүдийг бичсэн нь зохиолыг илүү сонирхолтой болгожээ. Дампил тэргүүтэй даргын яриаг хашир егзөр далд утга агуулсан хий зайгүй шулуухан найруулгаар, согтуу хүний яриаг согтуу хүний өнгө найруулгаар, хүүхэн хүний яриаг үгээ зөөж ичингүйрэн эргэлзсэн аясаар, эсвэл түс тас хийсэн хурдан шуурхай зэргээр зохиол дахь тухайн агшин бүрд нь тааруулан бичсэн нь зохиолыг илүү сонирхолтой болгосон байна.

Мажиг зохиолд аливаа асуудлыг удирдах албаны хүн юмуу аль эсвэл ажлын газрын хэн нэгэн, найз нөхөд зэрэгтэйгээ заавал ярилцаж, бусдын зөвлөгөө саналыг сонсож, аль зөв хэлсэн зүйлсийг тусган өөрийн шийдвэрийг гаргаж байдаг. Энэ бол Мажиг аливаа асуудал дээр тун бага алддаг, тэр хэмжээгээрээ амьдрал ахуй, ажил албан дээрээ нэр хүндтэй, өсөж хөгжиж байгаа гол үндэс нь болж байна. Зохиолч Л.Ванганы намтар, түүний тухай бичсэн хүмүүсийн дурсамж, судалгаа тэргүүтнээс харахад зохиолч бусадтай маш найрсаг харьцаатай, бусад хүмүүстэй их зөвлөлдөж, тэр хэмжээгээрээ ажил, албан дээрээ алдаа гаргадаггүй хашир нэгэн байсантай нь холбоотой байжээ.

Abstract

L.Vangan is famous representative of modern Mongolian literature. He was also a well-known producer of drama and movies. L.Vangan has written many works. L.Vangan expressed nomadic and modern life, psychological, and philosophical ideas in his writings. The novel “Erkhii Majig” is one of L.Vangan's famous novels. Writer L.Vangan wrote the main character in the novel "Erkhii Majig" in a very interesting way. The main character of this novel, Erkhii Majig, is a small but very intelligent man. He skillfully used the figurative imagery method to express the character of Erkhii Majig. Therefore, the role of Erkhii Majig is very important in modern Mongolian literature. Researchers believe that Majig is the writer L.Vangan himself. From this, it can be considered that the writer L.Vangan wrote his life in his novel “Erkhii Majig”.

Key words: *L.Vangan, “Erkhii Majig”, character, novel, craft, figurative imagery*

Номзүй

- Байгалсайхан С. 1998. *Уран дүрийн онолын лекцүүд*. Уб.
- Ванган Л. 1959. *Урагилах замд*. Улсын хэвлэлийн газар. Уб.
- Ванган Л. 1966. *Эрхий Мажиг*. Хошин шог тууж, өгүүллэг. Уб.
- Ванган Л. 1971. *Хэн хэлсэн юм бэ?* Улсын хэвлэлийн газар. Уб.
- Ванган Л. 2020. Бүрэн зохиол. Боть I, II, III. Эмх. А.Шартолгой. Уб.
- Галбаатар Д. 2012. *Уран зохиол: Онол, түүх, шүүмжлэл*. Нэвтэрхий толь. Уб.
- Галбаяр Г. 2002. *Уран зохиол шинжлэлийн лекц*. МУИС-ийн хэвлэх үйлдвэр. Уб.
- Лувсанвандан С. 1965. *Монголын орчин үеийн уран зохиолын гол баатар*. Уб.
- Лувсанвандан С. 1973. *Монголын орчин үеийн уран зохиолын онол түүхийн асуудалд*. Уб.
- МЗЭ. *Монголын зохиолчдын эвлэлийн III их хурал*. 1964. Уб.
- Тимофеев Л.И. 1972. *Основы теории литературы*. М.
- Ууганбаатар Ж. 2019. *Ламжавын Ванган. “XX зууны монгол зохиолчид” цуврал*. Боть-16. Уб.
- Цэнд-Аюуш Ш. 1981. *Монгол тууж*. Улсын хэвлэлийн газар. Уб.
- Цэдэв Д. 1978. *Зохиолчийн урлах эрдэм*. Уб.
- ШУА, ХЗХ. *Монголын орчин үеийн уран зохиол*. Гуравдугаар боть. (1961-1980) Уб., Редактор Х.Сампилдэндэв, Д.Цэнд, Ц.Мөнх. 1997. “Сүхбаатар” компани, Уб.
- Энхбаяр С. 2019. *Утга зохиолын ерөнхий онол туурвилзүй*. Уб.